ДОРНОД АЙМАГ
БАЯНТҮМЭН СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ

2026 оны 09 сарын 02 өдөр Дугаар 14/01 Цагаан дэрс

Ашигт малтмалын сонгон шалгаруулалтын
талбайн саналыг татгалзах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.13 дахь заалт, 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, Ашигт малтмалын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2 дахь заалт, Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь заалт, Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.5 дахь заалт, Усны тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.2.1 дэх заалт, Тариалангийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1.Ашигт малтмал, газрын тосны газрын 2026 оны 08 дугаар сарын 06-ны өдрийн 10/4562 дугаар албан бичиг, аймгийн Засаг даргын 2026 оны 08 дугаар сарын 13-ны өдрийн 01/1881 дүгээр албан бичгээр ирүүлсэн Баянтүмэн сумын нутагт 18,400.80 гектар талбайд ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийг сонгон шалгаруулалтаар олгох тухай мэдэгдлийг хэлэлцээд бүх талбайг сонгон шалгаруулалтаар олгохоос татгалзсугай.

2.Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олгохоос татгалзсан саналыг хавсралтаар баталсугай.

3.Уг саналыг холбогдох байгууллагад уламжилж ажиллахыг сумын Засаг дарга (П.Гунгаацэрэн)-д даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА Ж.БАТЧУЛУУН